# ТЕЛЕВИЗИЙН МОНИТОРИНГ

**2009.05.8- 2009.05.22**

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээ

“Глоб Интернэшнл” ТББ

# Мониторингийн хугацаа: 2009.5.8-5.22

- Мониторинг хийсэн эфир: 1324 цаг

  - МҮОНТВ-239
  - TV9 - 257
  - UBS - 270
  - MN25 - 275
  - TV5 - 282

Форс мажор-19



# ТЭНЦВЭРТ, ШУДАРГА БАЙДАЛ

# Нэр дэвшигчийн мэдээлэл /нийт 131 цаг/



# Нэр дэвшигчдэд цаг хуваарилалт

79 цаг

51 цаг






# Мэдээлэл хүргэсэн байдал




| | Шууд | Шууд бус |
|---|---|---|
| Н.Энхбаяр | 13:55:49 /20,2/ | 54:59:37 /79,8/ |
| Ц.Элбэгдорж | 9:28:39 /15,3/ | 52:25:58 /85,7/ |

- **Эерэг: -** магтсан, биширсэн, эерэг сэтгэгдэл төрүүлэхүйц
- **Сөрөг:** - сөрөг сэтгэгдэл төрүүлэхүйц, буруутгасан буюу нэг талыг барьсан байдал давамгайлсан
- **Төвийг сахисан:** - цэвэр мэдээллийн шинж чанартай, нэг талыг барьсан алив шүүмжлэл, үнэлэлт дүгнэлт агуулаагүй



# Мэдээллийн чанар буюу өнгө аяс



# Телевизүүдийн харьцуулалт






| | MYOHTB | TV5 | TV9 | UBS | MN25 |
|---|---|---|---|---|---|
| Н.Энхбаяр | 55.9 | 54.9 | 64.9 | 61.8 | 32.3 |
| Ц.Элбэгдорж | 44.1 | 45.1 | 35.1 | 38.2 | 67.7 |

# МЭДЭЭНИЙ БУС ХӨТӨЛБӨР: цаг хуваарилалт



# Мэдээний бус хөтөлбөр

**Мэдээллийн чанар /бусад нэвтрүүлэг/**




| | Н.Энхбаяр | | Ц.Элбэгдорж | |
|---|---|---|---|---|
| Эерэг | 28:20:27 | /75.6/ | 18:53:43 | /45/ |
| Төвийг сахисан | 4:32:53 | /12.1/ | 5:15:58 | /12.6/ |
| Сөрөг | 4:36:36 | /12.3/ | 17:34:45 | /42.1/ |

# Тав хоногоор харьцуулсан дүн






| | МҮОНТВ | TV5 | TV9 | UBS | MN25 |
|---|---|---|---|---|---|
| Н.Энхбаяр | 57.9 | 47.5 | 60.7 | 64.1 | 27.8 |
| Ц.Элбэгдорж | 42.1 | 52.5 | 39.3 | 35.9 | 72.2 |

# МЭДЭЭНИЙ ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН АЖИГЛАЛТ

# Мэдээний хөтөлбөрийн цаг



# Мэдээний хөтөлбөр




| | Н.Энхбаяр | Ц.Элбэгдорж |
|---|---|---|
| Эерэг | 26:06:36 /83.1/ | 10:21:44 /51.4/ |
| Төвийг сахисан | 4:20:43 /13.8/ | 3:08:06 /15.5/ |
| Сөрөг | 0:58:11 /3.1/ | 6:40:21 /33.1/ |

# НИЙТ /мэдээ/ (цаг хуваарилалт)




| | V/8-12 | V/13-17 | V/18-22 |
|---|---|---|---|
| Н.Энхбаяр | 6:19:53 | 12:49:20 | 12:16:17 |
| Ц.Элбэгдорж | 3:51:15 | 6:16:50 | 10:02:06 |

# Мэдээ төлбөргүй байх ёстой



# Тав хоногоор харьцуулбал






| | МҮОНТВ | TV5 | TV9 | UBS | MN25 |
|---|---|---|---|---|---|
| Н.Энхбаяр | 52.0 | 68.2 | 68.6 | 59.0 | 46.0 |
| Ц.Элбэгдорж | 48.0 | 31.8 | 31.4 | 41.0 | 54.0 |

# ДҮГНЭЛТ...

- Тоон үзүүлэлтийн нэгдсэн дүнг авч үзвэл, телевизийн сувгууд мэдээллийнхээ 53 хувийг МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаяр, 47 хувийг АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдоржид зориулсан нь зургаан хувийн зөрүүтэй, бараг тэнцвэртэй харагдаж байна. Мэдээний хөтөлбөрт Н.Энхбаярын тухай мэдээлэл 22 хувиар, бусад нэвтрүүлэгт Ц.Элбэгдоржийн тухай мэдээлэл 6 хувиар өрсөлдөгчөөсөө илүү байв.

# ДҮГНЭЛТ...

- Харин сурталчилгааны тэнцвэрт байдал суваг тус бүрт хэтэрхий ялгаатай байсан нь телевизүүд мэргэжлийн түвшинд ажиллаж чадаагүйг харуулж байна. Тухайлбал, Ц. Элбэгдоржийн тухай мэдээлэл  MN 25 сувагт 13 цагаар, Н.Энхбаярт зориулсан цаг TV9-д 10 цаг, UBS сувагт 17 цагаар тус тус өрсөлдөгчөөс нь илүү байна. Нэр дэвшигч Н. Энхбаярын тухай мэдээдэл TV5 сувагт хоёр цагаар илүү байсан нь арилжааны суваг дотроо харьцангуй тэнцвэртэй үзүүлэлт байв.

# ДҮГНЭЛТ...

- Мониторингид хамрагдсан телевизүүд нэр дэвшигчдийн тухай ихэнхдээ шууд бус мэдээлэл  (82,1%) мэдээлэл дамжуулжээ. Шууд мэдээллийн 20,2 хувь Н.Энхбаярт, 15,3 хувь нь Ц.Элбэгдоржид ногдсон байна. Өөрөөр хэлбэл, телевизүүд нэр дэвшигчдийн тухай хэн нэгэн хоёрдагч, гуравдагч этгээд өөрсдөөс нь илүү ярьжээ

# ДҮГНЭЛТ...

- Чанарын үзүүлэлтийн хувьд авч үзвэл, Нэр дэвшигчдийн тухай төвийг сахисан буюу бодит мэдээлэл 13 хувийг эзэлсэн байна. Сурталчилгааны үеэр Н.Энхбаярын талаар эерэг буюу хэт магтсан, дөвийлгөсөн мэдээлэл өрсөлдөгчийнхөөс нь 1,9 дахин их, харин нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн талаарх сөрөг буюу хэт муулсан, буруутгасан мэдээлэл Н.Энхбаярынхаас 4.3 дахин их цацагджээ

# ДҮГНЭЛТ...

- Мэдээний хөтөлбөрийн чанарын үзүүлэлтийг авч үзвэл, Н.Энхбаярын тухай мэдээллийн 83.1 хувь нь эерэг, сөрөг мэдээлэл бараг үгүй буюу ердөө 3.1 хувийг эзэлсэн байна. Харин Ц.Элбэгдоржийн тухай эерэг мэдээлэл 51.4 хувьтай, сөрөг мэдээлэл нь 33.1 хувьтай байсан. Хоёр нэр дэвшигчийн талаарх сөрөг мэдээллийн эзлэх хувийг хооронд нь харьцуулбал 10 дахин зөрүүтэй байна

# ДҮГНЭЛТ...

- МҮОНТВ нэр дэвшигчдийн талаарх мэдээлэлд хамгийн бага цаг буюу нийт эфирийнхээ дөрвөн хувийг хуваарилж, төвийг сахисан мэдээллийн хэмжээ нь  бусад телевизтэй харьцуулахад даруй 31-ээс 40 хувиар илүү байлаа.  Нэр дэвшигчдийн тухай эерэг, сөрөг мэдээлэл нь хол зөрүүгүй байна Тэнцвэрт байдлыг тоон үзүүлэлтээр авч үзэхэд,  хоёр нэр дэвшигчийн тухай мэдээллийн зөрүү нэг цаг буюу 12 хувьтай байлаа. Энэ нь МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярт ногджээ.

# ДҮГНЭЛТ...

- Төрийн мэдлээс гарч, олон нийтийн болсон МҮОНТ энэ жил анх удаа Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаанд оролцож, үүргээ зохих ёсоор биелүүлсэн байна. Хэдийгээр бүхий л ХМХ сонгуулийг хариуцлагатай мэдээлэх ёстой боловч олон түмнээс санхүүжиж буй олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд илүү өндөр шаардлага тавигдах нь зүйн хэрэг. ОНМХ нь иргэдийн татвараар үйл ажиллагаа явуулдаг учраас аль нэгэн улс төрийн хүчин, хувийн ашиг сонирхолд бус харин олон түмний ашиг сонирхолд үйлчлэх хууль ёсны төдийгүй ёс суртахууны үүрэг хүлээдэг.

# ДҮГНЭЛТ...

- 2009 оны 5 сарын 21-нд явуулсан нэр дэвшигчдийн халз ярилцлага сонгогчдын анхаарлын төвд байв. Мэргэжлийн үүднээс авч үзвэл, энэ нь халз ярилцлага гэхээсээ илүү урьдчилан бэлтгэсэн асуулттай, намуудад, нэр дэвшигчдэд хөтлөгдсөн гэмээр нэвтрүүлэг байсан ч хэт туйлширсан мэдээлэлд төөрөлдөж, бодит мэдээлэл хүсэж байсан сонгогчдод сонголтоо хийхэд нь ямар нэг хэмжээгээр тус болсон гэж үзэж байна.

# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.globeinter.org.mn

авна уу.